



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/49/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Орхон аймаг  
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Буян-ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: Buynundrakhb@audit.gov.mn  
Аудитор: Ж.Наранчимэг  
Утас: 70350757 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.08.25 № 143

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОРХОН АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ  
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ГАЗРЫН  
ДАРГА Х.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд 1 албан хаагчид 1,069.6 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон.
2. Тайлант оны 11 дүгээр сард алба хаагчдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан шагнал урамшуулалд 1,806.5 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон.
3. Байгууллагын бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн биет тооллого хийхэд 6,840.0 мянган төгрөгийн бараа материал дутсан.
4. Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн.

5. Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тушаалыг албан хаагчдын ажлыг үнэлж гаргахгүй жилийн эхэнд гаргасан 1 тушаалын дагуу бүтэн жил 71,502.5 мянган төгрөгийг олгосон.
6. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тайлант оны бараа материалын анхан шатны баримт шаардах хуудсанд шаардах хуудас бичсэн, хүлээн авсан ажилтан, зөвшөөрсөн нягтлан бодогчийн гарын үсэг зурагдаагүй байна.
7. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2 мэдээлэл хоцроож, бонд, зээл, ерийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр талбарт 15,455.0 мянган төгрөгийн 5 тушаалыг орхигдуулж мэдээлсэн.
8. Он дамнаж ээлжийн амралтаа авсан ажилтны 144.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй тайлагнасан.
9. Байгууллагын дарга, нягтлан бодогч солигдоход хөрөнгийн тооллого хийгээгүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар өвлийн хүлэмжгүй, цэцэрлэгжүүлэгчид өвөл хийх ажил багасдаг тул замын цас цэвэрлэж хот тохижуулах газрын ажилчдын ажлыг хийж 12,1,2 сард нийт 100,425.8 мянган төгрөгийн цалинг олгосон байна.

Тайлант онд бараа материалын үлдэгдэл 306,250.0 мянган төгрөгөөр өссөн байна.

#### **Аудитын гол асуудал**

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн, анхан шатны баримтыг шаардсан хугацаанд иж бүрэн Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан.

#### **Бусад асуудал**

Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн Б/18 дугаар захирамжаар байгууллагын дарга өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөж, ахлах мэргэжилтэн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн Б/37 дугаар захирамжаар даргыг буцаан томилсон байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

## Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>386,266,842.44</b>	<b>692,218,842.44</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>386,266,842.44</b>	<b>692,218,842.44</b>
35100	Түүхий эд материал	95,976,501.58	169,516,891.58
35110	Тусгай зориулалттай материал	95,976,501.58	169,516,891.58
35400	Хангамжийн материал	4,175,400.00	4,475,400.00
35410	Бичиг хэргийн материал	315,000.00	615,000.00
35420	Аж ахуйн материал	3,860,400.00	3,860,400.00
35500	Биологийн хөрөнгө	286,114,940.86	518,226,550.86
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,929,988,842.21</b>	<b>1,894,320,510.65</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,929,988,842.21</b>	<b>1,894,320,510.65</b>
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	1,873,849,562.17	1,838,198,550.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,773,374,018.63	1,773,374,018.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,386,275.63	-28,385,945.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	184,371,200.00	184,371,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-96,295,723.04	-113,271,331.40
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,432,200.00	45,432,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17,722,857.74	-28,348,216.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,571,000.00	17,571,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,583,400.09	-13,589,075.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,134,100.00	3,134,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,044,699.96	-2,089,399.92
39300	Биет бус хөрөнгө	56,139,280.04	56,121,960.08
39301	Програм хангамж	86,600.00	86,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-17,319.96	-34,639.92
39303	Бусад биет бус хөрөнгө	56,070,000.00	56,070,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,316,255,684.65</b>	<b>2,586,539,353.09</b>

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,316,255,684.65	2,586,539,353.09
51	Засгийн газрын хувь оролцоо	2,316,255,684.65	2,586,539,353.09
51100	Засгийн газрын оруулсан капитал	56,070,000.00	56,070,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	56,070,000.00	56,070,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,710,278,807.99	1,980,562,476.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,380,697,363.27	1,710,278,807.99
51220	Тайлант үеийн үр дүн	329,581,444.72	270,283,668.44
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	549,906,876.66	549,906,876.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,316,255,684.65	2,586,539,353.09

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,303,634,540.86	1,395,724,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193,073,340.86	322,647,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	193,073,340.86	322,647,000.00
120018	үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	193,073,340.86	322,647,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,110,561,200.00	1,073,077,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,110,246,200.00	1,072,867,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,110,246,200.00	1,072,867,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	970,224,738.20	1,125,440,931.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	970,224,738.20	1,125,440,931.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	905,200,897.94	1,030,806,949.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,259,595.17	708,722,204.52
210101	Үндсэн цалин	411,893,814.57	395,004,672.88
210102	Нэмэгдэл	85,930,834.88	249,520,451.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,237,671.72	39,562,227.28
210104	Урамшуулал	20,197,274.00	24,634,853.20

210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,706,398.99	87,431,872.07
210201	Тэтгэврийн даатгал	46,645,227.81	60,101,080.25
210202	Тэтгэмжийн даатгал	5,493,778.44	7,041,458.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,395,022.84	3,889,210.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,015,668.64	3,280,024.64
210205	Эрүүл мэндийн даатгал	10,156,701.26	13,120,098.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,808,413.08	16,883,703.22
210301	Гэрэл, цахилгаан	1,826,148.32	2,518,229.71
210302	Түлш, халаалт	3,535,664.52	3,282,052.49
210303	Цэвэр, бохир ус	2,809,800.24	2,011,421.02
210304	Байрны түрээс	4,636,800.00	9,072,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,993,127.00	73,858,878.00
210401	Бичиг хэрэг	2,923,350.00	2,785,300.00
210402	Тээвэр, шатахуун	52,812,180.00	51,965,432.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,661,697.00	1,804,896.00
210404	Ном, хэвлэл	0.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	246,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,415,100.00	1,402,250.00
210408	Бараа материал акталсны зардал	5,934,800.00	15,455,000.00
2105	Нормативт зардал	12,014,000.00	7,026,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,014,000.00	7,026,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,533,100.00	19,877,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,342,000.00	8,377,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,321,900.00	3,184,200.00
210604	Урсгал засвар	16,869,200.00	8,316,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,208,000.00	0.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,208,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,793,023.92	80,938,760.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,713,681.42	80,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	272,520.00	272,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,372.50	237,290.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	23,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	312,500.00
210807	Газрын төлбөр	93,450.00	93,450.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,885,239.78	36,068,331.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,670,000.00	400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,215,239.78	35,668,331.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,023,840.26	94,633,982.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,050,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,973,840.26	93,633,982.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,973,840.26	93,633,982.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	333,409,802.66	270,283,668.44
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,828,357.94	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,828,357.94	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	329,581,444.72	270,283,668.44

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,110,561,200.00	1,073,077,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,110,561,200.00	1,073,077,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	210,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	210,000.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,110,246,200.00	1,072,867,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,110,246,200.00	1,072,867,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,091,012,300.00	1,073,077,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,091,012,300.00	1,073,077,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,025,988,459.74	978,443,617.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,259,595.17	708,722,204.52
210101	Үндсэн цалин	411,893,814.57	395,004,672.88
210102	Нэмэгдэл	85,930,834.88	249,520,451.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,237,671.72	39,562,227.28
210104	Урамшуулал	20,197,274.00	24,634,853.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,706,398.99	87,431,872.07
210201	Тэтгэврийн даатгал	46,645,227.81	60,101,080.25
210202	Тэтгэмжийн даатгал	5,493,778.44	7,041,458.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,395,022.84	3,889,210.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,015,668.64	3,280,024.64
210205	Эрүүл мэндийн даатгал	10,156,701.26	13,120,098.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,808,413.08	16,883,703.22
210301	Гэрэл, цахилгаан	1,826,148.32	2,518,229.71
210302	Түлш, халаалт	3,535,664.52	3,282,052.49
210303	Цэвэр, бохир ус	2,809,800.24	2,011,421.02
210304	Байрны түрээс	4,636,800.00	9,072,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,375,327.00	57,163,878.00
210401	Бичиг хэрэг	2,923,350.00	2,785,300.00
210402	Тээвэр, шатахуун	51,462,180.00	50,725,432.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,661,697.00	1,804,896.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	246,000.00	246,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,082,100.00	1,402,250.00
2105	Нормативт зардал	12,074,000.00	7,026,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,074,000.00	7,026,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,239,100.00	19,877,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,748,000.00	8,377,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,591,900.00	3,184,200.00
210604	Урсгал засвар	19,899,200.00	8,316,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,208,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,208,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	281,647,625.50	80,938,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	280,568,283.00	80,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	272,520.00	272,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,372.50	237,290.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	23,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	312,500.00
210807	Газрын төлбөр	93,450.00	93,450.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,670,000.00	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,670,000.00	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,023,840.26	94,633,982.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,050,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,973,840.26	93,633,982.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,973,840.26	93,633,982.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,548,900.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,548,900.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,548,900.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,548,900.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,548,900.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,548,900.00	0.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,070,000.00	549,906,876.66	1,380,697,363.27	1,986,674,239.93
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,070,000.00	549,906,876.66	1,380,697,363.27	1,986,674,239.93
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	329,581,444.72	329,581,444.72
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,070,000.00	549,906,876.66	1,710,278,807.99	2,316,255,684.65
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	56,070,000.00	549,906,876.66	1,710,278,807.99	2,316,255,684.65
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,070,000.00	549,906,876.66	1,710,278,807.99	2,316,255,684.65
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	270,283,668.44	270,283,668.44
20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	56,070,000.00	549,906,876.66	1,980,562,476.43	2,586,539,353.09

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,072,867,600.00	979,233,617.81	93,633,982.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,072,867,600.00	979,233,617.81	93,633,982.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,043,305,700.00	978,233,617.81	65,072,082.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	759,793,200.00	708,722,204.52	51,070,995.48
210101	Үндсэн цалин	401,548,600.00	395,004,672.88	6,543,927.12
210102	Нэмэгдэл	308,586,200.00	249,520,451.16	59,065,748.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,658,400.00	39,562,227.28	10,096,172.72
210104	Урамшуулал	0	24,634,853.20	- 24,634,853.20

210105	Гэрээт ажлын хөлс	0	100	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,974,100.00	87,431,872.07	10,542,227.93
210201	Тэтгэврийн даатгал	66,622,400.00	60,101,080.25	6,521,319.75
210202	Тэтгэмжийн даатгал	7,837,900.00	7,041,458.33	796,441.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,384,500.00	3,889,210.59	495,289.41
210204	Ажилгүйдлийн даатгал	3,453,400.00	3,280,024.64	173,375.36
210205	Эрүүл мэндийн даатгал	15,675,900.00	13,120,098.26	2,555,801.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,908,900.00	16,883,703.22	1,025,196.78
210301	Гэрэл, цахилгаан	2,376,000.00	2,518,229.71	-142,229.71
210302	Түлш, халаалт	3,652,900.00	3,282,052.49	370,847.51
210303	Цэвэр, бохир ус	2,808,000.00	2,011,421.02	796,578.98
210304	Байрны түрээс	9,072,000.00	9,072,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,027,000.00	56,953,878.00	1,073,122.00
210401	Бичиг хэрэг	2,575,300.00	2,575,300.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	51,589,500.00	50,725,432.00	864,068.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,998,000.00	1,804,896.00	193,104.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	246,000.00	4,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,414,200.00	1,402,250.00	11,950.00
2105	Нормативт зардал	7,026,000.00	7,026,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,026,000.00	7,026,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,877,200.00	19,877,200.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,377,000.00	8,377,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,184,200.00	3,184,200.00	0.00
210604	Урсгал засвар	8,316,000.00	8,316,000.00	0.00

2107	Томилолт, зочны зардал	800,000.00	0	800,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	0	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,399,300.00	80,938,760.00	460,540.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000,000.00	80,000,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,000.00	272,520.00	7,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254,000.00	237,290.00	16,710.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	23,000.00	142,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	312,500.00	187,500.00
210807	Газрын төлбөр	200,300.00	93,450.00	106,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	400,000.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	400,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,561,900.00	1,000,000.00	28,561,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,561,900.00	1,000,000.00	28,561,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,561,900.00	0	28,561,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,072,867,600.00	979,233,617.81	93,633,982.19
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,072,867,600.00	979,233,617.81	93,633,982.19
320001	Орон нутгийн төсвөөс	1,072,867,600.00	979,233,617.81	93,633,982.19

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 81,362.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 7,909.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,806.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 71,646.5 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулаагүй 9 зөрчилтэй асуудал нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс их байгаа хязгаарлалттай дүгнэлт өгсөн болно.

### **3.1 Төлбөрийн акт**

Тайлант онд 1 албан хаагчид 1,069.6 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон, байгууллагын бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн биет тооллого хийхэд 6,840.0 мянган төгрөгийн бараа материал дутсан зөрчлүүдэд 2 төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 1,806.5 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллалгүй зөрчлийг давтан гаргасан 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой**

##### **Илрүүлэлт: 1**

Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлж байх.

#### **2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт: 2**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2 мэдээлэл хоцроож, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр талбарт 15,455.0 мянган төгрөгийн 5 тушаалыг орхигдуулж мэдээлсэн байна.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх";, 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлж байх.

**1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт: 3**

Байгууллагын дарга, нягтлан бодогч солигдоход хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Эд хөрөнгө хариуцагч солигдох үед хөрөнгийн тооллого хийж байх.

**2. Цалин хөлстэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт: 4**

Тайлан оны 1 сард гаргасан тушаалыг үндэслэн жилийн турш 71,502.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.10-т "дарга эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Ур чадварын нэмэгдлийг ажилчдад олгохдоо байгууллагын дарга тушаал гаргаж, журмын дагуу сар бүр дүгнэн олгох.

**3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт: 5**

Он дамнаж ээлжийн амралтаа авсан ажилтны 144.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"

**Өгсөн зөвлөмж:**

Жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөө тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орлого, үр дүнгийн тайланд 15,455.0 мянган төгрөгийг бараа материал акталсан зардалд тусгасан байтал бараа материалын тайланд тусгаагүй	1	15,455.0			1	15,455.0	1	15,455.0				
Бараа материалын тайланд худалдан авсан 8,885.0 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар авсан гэж буруу тайлагнасан.	1	8,885.0			1	8,885.0	1	8,885.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>24,340.0</b>			<b>2</b>	<b>24,340.0</b>	<b>2</b>	<b>24,340.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 1 албан хаагчид 1,069.6 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон байна.	1	1,069.6	1	1,069.6								
Байгууллагын бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн биет тооллого хийхэд 6,840.0 мянган төгрөгийн бараа материал дутсан.	1	6,840.0	1	6,840.0								

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 1,806.5 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон	1	1,806.5			1	1,806.5						
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тайлант оны бараа материалын анхан шатны баримт шаардах хуудсанд шаардах хуудас бичсэн, хүлээн авсан ажилтан, зөвшөөрсөн нягтлан бодогчийн гарын үсэг зурагдаагүй байна.	1	0			1	0						
Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн.	1	0					1	0				
Байгууллагын дарга, нягтлан бодогч солигдоход хөрөнгийн тооллого хийгээгүй байна.	1	0					1	0				
Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тушаалыг албан хаагчдын ажлыг үнэлж гаргахгүй жилийн эхэнд гаргасан 1 тушаалын дагуу бүтэн жил 71,502.5 мянган төгрөгийг олгосон байна.	1	71,502.5					1	71,502.5				
Он дамнаж ээлжийн амралтаа авсан ажилтны 144.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй тайлагнасан байна.	1	144.0					1	144.0				
Дүн	8	81,362.6	2	7,909.6	2	1,806.5	4	71,646.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2 мэдээлэл хоцроож, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр талбарт 15,455.0 мянган төгрөгийн 5 тушаалыг орхигдуулж мэдээлсэн байна	1	0			0	0	1	0
Дүн	1	0			0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

